МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 22 өдөр Дугаар А/445 Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өндрөөс унасны улмаас биеийн байдал хүнд, аймгийн сэхээн амьдруулах тасагт эмчлүүлж байгаа Даваадорж овогтой Гарьд хүүг Улаанбаатар хотын гэмтэл согог судлалын үндэсний төвд шилжүүлэн хэвтүүлэхээр нисдэг тэргээр зөөвөрлөх зардалд 2,000,000 (Хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дансны "Орон нутгийн нөөц хөрөнгө" зардлаас гаргаж шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Д.Балжинням)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712010940